

Дашдаваагийн өөлд Халуун голд нүүсэн тухай

О.Оюунжаргал*

0. Оршил

Манж Дайчин улсын хааны зуны ордон болох Халуунаас зайлах ордны (одоогийн БНХАУ-ын Хэбэй мужийн Чэндэ хот) ойролцоо байх Хол дахиныг амаржуулагч сүм (安遠廟)-ийг 1764 онд тэнд суух Дашдаваагийн харьяат өөлд нарт зориулж, Илийн Гулз сүмийг дуурайлган барьсан гэдэг.

Дашдаваа бол Зүүнгарын бага Цэрэндондовын хүү, цоросын томоохон тайж байжээ. 1750 онд эцэг нэгт Цэвээндоржнамжилыг Зүүн Туркестанд хорьж, Зүүнгарын хунтайж болохыг санаархсан Ламдаржааг эсэргүүцэж, Амарсанаа, Даваач нар Цэвээндоржнамжилын дүү Мангусыг хунтайжид өргөмжлөх гэж оролдов. Түүнийг нь мэдсэн Ламдаржаа эхлээд Мангусыг барьж алахад, Амарсанаа, Даваач хоёр Хасагт зугтав. Ламдаржаа мөн өөрийг нь буруутгасан цоросын тайж Дашдавааг хороосонд, түүний зайсан Саарал(saral, 薩喇勒) 300 орчим хүнийг дагуулан Манжид дагаар оров. Тэнгэрийн тэтгэсэн хаан Сааралд сул сайдын зэрэг хүртээж, харьяатаар нь хондого зохиогоод Цахарын Шулуун хөх хошуунд суулгажээ.¹

Түүний дараа 1752 онд Амарсанаа, Даваач хоёр Ламдаржааг алж, Даваач Зүүнгарын хунтайж болсон авч удалгүй тэр хоёр муудалцаж, 1754 онд Амарсанаа харьяат ардыг дагуулан Манжид дагаар оров. Энэ мэт Зүүнгарын дотоодын тэмцлийг далимдуулж, Манж Чин улс Зүүнгарыг дайлахаар 1755 оны хавар хойт, баруун хоёр замаар их цэрэг давшуулав. Тэгэхэд Амарсанаа Хязгаар дахиныг тохинуулах зүүн этгээдийн туслагч жанжин(хойт зам). Саарал Хязгаар дахиныг тохинуулах баруун этгээдийн туслагч жанжин (баруун зам)-ы тушаалд тус тус томилогдож, 1755 оны 7 сар гэхэд Илд хүрч, Даваачийг барьснаар Зүүнгар улс мөхөв. 1755 оны намар Амарсанаа Манжаас урваж, бослого гаргасан боловч Тэнгэрийн Тэтгэсэн хаан Зүүнгарыг эзлэсний дараа халхын нутагт суух ойрадуудын уг нутагт нь буцаах бодлого баримталж, Заг Байдраг, Орхон зэрэг халхын нутагт сууж байсан дөрвөд, хойд, хошуудыг

* Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Түүхийн Хүрээлэн

¹ Магад хууль (Гаозун хааны 『高宗實錄』 : 『清實錄』 中華書局影印, 中華書局出版, 1986), дэвтэр 373, Тэнгэрийн Тэтгэсний 15 оны 9 сарын хар нохой (23) өдрийн зурвас.

уг нутагт нь нүүлгэхээр бэлтгэж байсан билээ. Гэтэл Дашдаваагийн харьяат нар 1755 онд Илээс гарч Бархөл, Алтай, Орхоноор дамжин 1759 онд Халуунголд хүрсэн, өөрөөр хэлбэл бусад ойрадуудаас эсрэг зүгт нүүсэн байдаг.²

Энэ тухай Хятадын судлаач Юань Сэн По бээр, Дашдаваагийн харьяат нар Манжид даган орсон, Илээс Халуун голд хүрсэн тухай он цаг, үйл явдлыг тодорхойлон өгүүлжээ. Чингэхдээ Амарсанаа Дашдаваагийн эхнэрийг хүчээр авах гэсэн учраас тэрбээр харьяат олныг дагуулан Илээс Бархөлд зугтаж, Манжийн цэргийн өмгөөлөл дор орсон болохыг онцлон тэмдэглэсэн авч чухам юуны учир Алтай, Орхоноор дамжин Халуунголд нүүсэн тухай хөндөж үзсэнгүй.³ Тиймээс эл өгүүлэлд Дашдаваагийн харьяат өөлдийн нүүдлийг дахин мөшгөн үзэж, тийнхүү нүүсэн шалтгааныг тодруулахыг оролдоно.

1. Манжид дагасан ба Алтайд нүүсэн нь

Манжийн хоёр замын цэрэг 1755 онд бараг эсэргүүцэл үзэлгүйгээр Ил хүртэл давшиж, Зүүнгарыг мөхөөв. Зүүнгарт довтлохын өмнө 1755 оны цагаан сард Цэргийн тухайн сайд нар хэлэлцсэн “Зүүнгарыг тохинуулах зүйл”-ийн гол агуулга нь ойрадын тайж нарт хэргэм, тушаал өргөмжилж, хошуу, сум зохиох байсан бөгөөд түүнийг Хязгаар дахиныг тохинуулагч жанжин Банди(bandi, 班第) нарт даалгажээ. Чингээд Илд одсон жанжин Банди нар ойрад, түүний дотор Дашдаваагийн харьяатыг хэрхэх тухай дараах мэт айлтгажээ.

“軍機大臣議覆、定北將軍班第奏準噶爾善後事宜、... 一、扎哈沁·包沁人衆、應俱遷阿爾台等處。小策零敦多布之子達什達瓦、為喇嘛達爾扎所殺、部衆分散、今俱歸降。聞伊有子圖魯巴圖、逃入回部、如訪得、即令統舊衆。查扎哈沁·包沁之人、應如所奏遷移。達什達瓦之子圖魯巴圖、訪得與否、均未可定。請將達什達瓦部衆、擇人心推服之宰桑統領。... 從之。”

“Цэргийн тухайн сайд хэлэлцээд айлтгасан нь: Хязгаар дахиныг тохинуулагч жанжин Бандийн айлтгасан Зүүнгарыг тохинуулах хэргийн зүйлд, ... нэгэн зүйл. Захчин, буучины ардыг цом Алтайн зэрэг газар нүүлгэвээс зохино. Бага Цэрэндондовын хүү Дашдаваа болбаас Ламдаржаад алагдаж, харьяат олон сарнин тархсан нь эдүгээ цөм дагаж оров. Сонсвоос, түүний хүү Төрбат Хотонд зугтсан ба хайж олбол хуучин ардыг захируулбаас зохимуй. Байцааваас, Захчин буучины ардыг айлтгасан ёсоор нүүлгэвээс зохино. Дашдаваагийн хүү Төрбат олдох эсэх эргэлзээтэй, баталж үл болно. Дашдаваагийн харьяатыг тэдний сэтгэл дагах зайсанг сонгож, захируулах явдлыг гуйя. ... Айлтгасан ёсоор болго.”

Өөрөөр хэлбэл, Дашдаваа нэгэнт үгүй болсон, бас түүний хүү Төрбат Хотонд зугтаж, сураггүй болсон тул харьяатыг зайсанд захируулах зарлиг буужээ. Гэтэл Хязгаар дахиныг тохинуулах

² Манж Чин улс Зүүнгарыг эзлэхээс өмнө “ойрадуудыг язгуур нутагт нь суулгаж, захирах” үндсэн чиглэл-бодлого боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэхийг оролдож байсан боловч, гагц Амарсанаа төдийгүй Зүүнгарын хуучин ноёдын ээлж дараалсан урвалт- боолого, түүнээс үүдсэн дайн самууныг дарахын тулд 1757 оны эхнээс бодлогоо өөрчилж, “сэжиг бүхий “ойрадуудыг устгах, боол болгох, Хармөрөн зэрэг газар нүүлгэх зэрэг арга хэмжээ авч эхэлсэн билээ. Харин Дашдаваагийн өөлд нар бүр 1755 онд Илээс гарч дараа жил нь Бархөл, Алтайгаар дамжин Орхонд нүүсэн байдаг.

³ Юань Сэн По “Дашдаваагийн ард зүүнш Халуун голд нүүсэн тухай(袁森坡 “達什達瓦部東遷熱河考” “衛拉特史論文集”, 內蒙古師範大學報哲社版), 1990, тал 173-183.

⁴ Магад хууль (Гаозун хаан) дэвтэр 492, Тэнгэрийн Тэггэсний 20 сарын 7 сарын цагаан луу өдрийн (8) өдрийн зурвас.

зүүн этгээдийн туслагч жанжин Амарсанаа түүнийг ашиглаж, өөрийн үеэл Шажинбат (Sajinbatu, 沙津巴圖)-д Дашдаваагийн харьяатыг захируулах гэснийг Дашдаваагийн зайсан асан Саарал дээш айлтгаж, Дашдаваагийн харьяатаар “энгийн сум” зохиохыг гуйсныг ёсоор болов.

「定邊右將將軍薩喇勒等奏言、聞阿睦爾撒納、欲將達什達瓦所屬數千戶、請給伊姊子沙津巴圖管轄。應請旨將達什達瓦屬人、作為公中管理、併給與游牧地方、以絕其僥倖之心。奏入、得旨。軍機大臣議奏。尋議、現在遵旨傳諭將軍班第等、俟辦理阿睦爾撒納後、將伊所占達什達瓦屬下、及各部落人等、分別給還本部、或編次歸公。今達什達瓦部衆分散、有見大兵前進、陸續來投。亦有伊等自行收集者、應查出極貧之戶、較賞給阿睦爾撒納屬人口糧數目酌減。每人給與馬一匹、羊二隻、每二人合給乳牛一隻。其德勒格爾之子沙津巴圖·特古斯、哈什哈之子布圖庫、祇應給與伊等舊日屬人。所有達什達瓦·車凌那木扎爾·伯格里等屬人、作為公中管理。至達什達瓦之孀婦、酌量給與戶口、以資養贍。此項人衆、應于今年移往舊游牧哈喇沙爾地方、從庫車等回部支給口糧、明年令在博克達種地、俟秋收後、移往科卜多·布延圖居住。又臣等奉旨、以達什達瓦之妻、不與阿睦爾撒納結婚、應賞給封號、以示獎壞。請俟辦理阿睦爾撒納後、再行具奏請旨、奏入。上從之。」⁵

“Хязгаар дахиныг тохинуулах баруун этгээдийн туслагч жанжин Саарал нар айлтгасан нь: “Амарсанаа Дашдаваагийн харьяат хэдэн мянган өрхөд шунаж, түүний үеэл Шажинбагад захируулахыг гуйжээ. Олбаас, Дашдаваагийн харьяатыг энгийн болгон захирч, бас нутаг олговол түүний хомхой санааг таслана.” хэмээсэнд Тусгай зарлиг: Цэргийн тухайг сайд нар хэлэлцсэн нь: “Эдүгээ зарлигийг даган жанжин Банди нарт, Амарсанааг шийтгэсний хойно түүний эзэлсэн Дашдаваагийн харьяат болоод бусад аймгийн хүмүүсийг уг газарт нь буцаах эс бөгөөс энгийн болгон зохиохыг захив. Эдүгээ сарнисан Дашдаваагийн харьяат нар их цэрэг давшихын хэрээр дараа дараагаар даган оров. Бас тэд өөрсдөө цугласан бол машид ядуу өрхийг байцаан гаргаж, Амарсанаагийн харьяат нарыг шагнах хүнснээс гаргаж, тохируулан шагна. Хүн бүрт морь нэг, хонь хоёр, хоёр хүн тутамд саалийн үнээ нэгийг өгье. Түүнээс Дэлгэрийн хүү Шажинбат, Төгс, Хашихагийн хүү Бүтэх нарт гагц тэдний хуучин харьяатыг өгвөл зохино. Дашдаваа, Цэрэннамжил, Бэгэли нарын харьяатыг энгийн болгож, захирья. Харин Дашдаваагийн бэлбэсэн эмд өрх ам хуваан өгч, асран тэжээе. Эдгээр ардыг энэ жил уг нутаг Харшард нүүлгэж, Куша зэрэг хотон аймгаас хүнс олгон өгөөд, хойтон жил Богдын газар тариа тариулж, намар ургац хураасны хойно Ховд-Буянтад нүүлгэн суулгая. Бас боолуудад зарлиг буулгаж, Дашдаваагийн эхнэр Амарсанаатай ураг холбоогүй, цол шагнаж хөхүүлбээс зохих ажааму. “Дээрхийг айлтгасан ёсоор болго.”

Хязгаар дахины баруун этгээдийн жанжин болж Илд суух Амарсанаа, гагц Дашдаваагийн харьяат төдийгүй бусад ойрадыг өөрийн захиргаанд оруулж, бүх ойрадыг захирах санаатай байсан гэдэг.⁶ Тухайлбал, Дашдаваагийн бэлбэсэн эхнэртэй ураг холбох замаар түүний харьяат хэдэн мянган өрхийг өөрийн захиргаанд оруулахыг санаархаж байсан ажээ. Тиймээс Цэргийн тухайн сайд нар, Амарсанаагийн захирахыг “завдсан” Дашдаваагийн харьяат нарын хүмүүсийг дээрх мэт хуучин эзэнд нь өгөх, захирах эзэнгүй Дашдаваагийн харьяат мэгийг “энгийн 公中” өөрөөр хэлбэл, засаг тавилгүй зайсан-бүгдийн даргад захируулахаар тушаажээ. Чингээд Тэнгэрийн тэтгэсэн хаан Халуунголд бараалхахаар ир хэмээн дуудсаны дагуу

⁵ Магад хууль (Гаозун хааны), дэвтэр 494, Тэнгэрийн Тэтгэсний 20 сарын 8 сарын цагаан нохой(9) өдрийн зурвас.

⁶ Магад хууль (Гаозун хааны), дэвтэр 492, Тэнгэрийн Тэтгэсний 20 сарын 7 сарын улаагчин гахай (15) өдрийн зурвас. Мөн дэвтэр 494, Тэнгэрийн Тэтгэсний 20 оны 8 сарын цагаан нохой(9) өдрийн зурвас.

Амарсанаа Илээс гармагц, жанжин Банди урд “сураггүй” хэмээгдэж байсан Дашдаваагийн хүү Төрбат хэдийн нас барсан хэмээн үзэж, Сааралын ах Бүрин (bürin, 布林) нарын гурван хүнийг бүгдийн дарга, мэйрэн зангид томилж, Дашдаваагийн харьяатыг захируулах болов.

“軍機大臣等議覆、定北將軍班第奏稱、... (中略)... 又奏稱、達什達瓦之子圖魯巴圖、為達瓦齊所殺。其來降部衆、應擇人統領。臣等公同酌議、臣薩喇勒之兄布林、諳悉事務、人心推服、請賞給職銜、令其總管。但人數衆多、應設左右翼協理。有舊宰桑巴雅斯呼朗·博羅呼爾噶、可以信任、請給職銜、令其協理等語。應如所奏。請旨將布林授散秩大臣、令柏總管、巴雅斯呼朗·博羅呼爾噶、授頭等侍衛、令柏副總管。”

“Цэргийн тухайн сайд нарт дахин айлтгасан нь: Хязгаар дахины жанжин Банди айлтгасан нь: ... (товчлов)... Бас айлтгасан нь: Дашдаваагийн хүү Төрбат Даваачид алагджээ. Түүний даган ирсэн ардыг таарах хүн сонгож, нэгтгэн захиргаваас зохино. Боол бид нийлэн хэлэлцээд боол Сааралын ах Бүрин хэрэгт тодорхой, олны сэтгэл дагах тул тушаал шагнаж, ерөнхийлөн захируулахыг гуйя. Гэвч хүний тоо олон, зүүн баруун гар зохиож, нийлүүлэн шийтгэвээс зохимуй. Хуучин зайсан Баясгалан, Борхургыг томилж болох мэт тул зохих тушаал шагнаж, нийлүүлэн шийтгэе хэмээн айлтгав. Айлтгасан ёсоор болго. Зарлигийг гуйж Бүринийг сул сайд, үлдсэн бүгдийн дарга Баясгалан, Борхургад тэргүүн зэргийн хиа өргөмжилж, үлдсэнийг дэд бүгдийн дарга болго.”

Харин Амарсанаа Халуунголд одох замаас буцаж, Манжийн эсрэг босоход түүний бослогын цэргээс зугтаж Дашдаваагийн эхнэр харьяатаа дагуулан 11 сард Илээс зугтаж, Бархөлд хүрч иржээ.

“上、諭軍機大臣曰、據策楞奏、達什達瓦之妻、遣宰桑薩喇爾族弟哈柳、侍衛滿楚等告稱、自伊犁前來、兩次遇敵衝突、率領屬人來歸等語。達什達瓦之妻、深知大義。率領屬下、棄賊來歸、深屬可嘉。昨已遣副都統鄂實傳旨、將達什達瓦之妻、賞給名號、並賜以銀兩緞疋。著和起仍照前旨辦理。并令在巴里坤附近過冬、俟明年向阿爾台地方遷移居住。侍衛滿楚、奮身脫出、著授爲二頭侍衛。宰桑哈柳、護送薩喇勒之子玉魯斯前來、亦著加恩授爲藍翎侍衛。仍照哈柳所請、明年前往薩喇勒游牧察哈爾地方居住。”

“Дээрх Цэргийн тухайн сайд нарт буулгасан нь: Цэрэнгийн айлтгасныг үзвэл, Дашдаваагийн эхнэрийн зарсан Сааралын төрлийн дүү Халиун, хиа Манч нарын мэдүүлсэн нь: Илээс ирэх замд хоёр удаа дайсанд цохигдож, харьяатаа дагуулан ирэв хэмээв. Дашдаваагийн эхнэр ёс журам гүнзгий мэдэх. Харьяатаа дагуулж, хулгайг орхин дагаж ирсэн нь туйлаас сайшаалтай. Урд нэгэнт зарсан мэйрэн занги Эшид зарлигийг дамжуулж, Дашдаваагийн эхнэрт цол шагнаж, мөнгө торго хүртээ. Хө Чи хэвээр урд тушаасан ёсоор шийтгэ. Бас Бархөлийн ойр өвлийг өнгөрөөж, дараа жилийг хүлээж байгаад Алтай нутагт нүүлгэн суулгая. Хиа Манч хүч гарган зугтан гарсан, дэд зэргийг хиа өргөмжил. Зайсан Халиун болбаас Сааралын хүү Юлусыг хамгаалж авчирсан, мөн хишиг хүртээж хөх отгот хиа өргөмжил. Бас Халиуныг гуйсан ёсоор дараа жил Цахарт хүргэж, Сааралын нутагт суулга”

⁷ Магад хууль (Гаозун хааны), дэвтэр 495, Тэнгэрийн Тэтгэсний 20 оны 8 сарын хөхөгчинүхэр (24) өдрийн зурвас.

⁸ Зүүнгарын бодлогын бичиг (Зарлигаар тогтоосон Зүүнгарыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг 『平定準噶爾方略』 西藏學漢文文獻彙刻, 第二輯, (清)傅恒等撰, 西藏社會科學院西藏學漢文文獻編輯室, 全國圖書館文獻縮微復制中心, 1987) жинхэнэ тэмдэглэл 21, Тэнгэрийн Тэтгэсний 20 оны 11 сарын харагчин тахиа (4) өдрийн зурвас.

Энэ үед Дашдаваагийн эхнэрт урд Амарсанаатай ураглаагүй, эдүгээ харьяатыг авч Манжийн цэргийг түшиж ирсэн хэмээн сайшааж, “Цэцэн мэргэн хатан” цол шагнажээ. Тэгээд Бархөлийн ойр ирсэн Дашдаваагийн харьяат тэнд өвөлжөөд, 1756 онд Алтайд нүүж, хошуу сум зохиохоор болжээ.

“軍機大臣議奏、巴里坤將軍和起奏稱、達什達瓦之妻、所遣宰桑博羅呼爾哈、請仍補放頭等侍衛 兼副總管。得旨、從前達什達瓦屬下來降、因無人管理、是以補放總管副總管統轄。今達什達瓦之妻、親自率屬前來、不便仍放總管等管轄。著將此存案、俟伊等徙於阿爾台等處後、照他項厄魯特例、編為佐領。倘嗣續無人、將補放總管副總管之處、再行辦理。”

“Цэргийн тухайн сайд нар айлтгасан нь: Бархөлийн жанжин Хө Чи айлтгасан нь: Дашдаваагийн эхнэр зайсан Борхургыг илгээж, хэвээр тэргүүн зэргийн хиа бөгөөд дэд бүгдийн даргад нөхөн тавихыг гуйв. Тусгай зарлиг: Урд Дашдаваагийн харьяат даган ирэхэд захирах хүн байхгүй тул дэд бүгдийн дарга, бүгдийн дарга нөхөн тавьж захируулав. Эдүгээ Дашдаваагийн эхнэр оорийн биеэр харьяатыг дагуулан ирсэн, хуучин хэвээр бүгдийн дарга нараар захируулах нь төвөгтэй. Үүнийг дансанд тэмдэглэж, хожим тэд Алтайн газар нүүсний дараа бусад өөлдийн хууль ёсоор сум зохио. Хэрэв үе залгамжлах хүн байхгүй аваас бүгдийн дарга, дэд бүгдийн даргыг нөхөн тавих газрыг дахин шийтгэе.”

Түүний дараа Тэнгэрийн тэтгэсний(ТТ) 21 буюу 1756 оны 3 сард Тэнгэрийн тэтгэсэн хаан, Амарсанаагийн бослогын цэрэгт дийлдэж, зугтсан Сааралыг барьж Бээжинд хүргүүлэх, тэгэхдээ зугтсан ял ганц Сааралд хамаарах бөгөөд Дашдаваагийн эхнэр болоод Сааралын ах Бүрин нарт хамаарахгүй болохыг тэдэнд ухуулахыг хуувийн сайд Жао Хуй (兆惠)-д тушаав.

“上、諭軍機大臣曰、薩喇爾現已降旨拏問。俟到京時、審訊治罪。著傳諭兆惠、俟伊犁事竣後、回至巴里坤、將拏問薩喇爾之處、明白曉諭達什達瓦之妻、及薩喇爾之兄布林等知悉。仍諭布林、罪由薩喇爾一人、與伊無涉、毋庸疑懼。薩喇爾子弟等、若尚未送至察哈爾地方、命留於達什達瓦部落內管轄。如已至中途、命令送來京。¹⁰⁹”

“Дээрх цэргийн тухайн сайд нарт зарлиг буулгасан нь. Сааралыг барьж байцаах зарлиг хэдийн буулгасан. Бээжинд хүрч ирсэн хойно байцааж, ял асууна. Илийн хэргийг дууссан хойно Бархөлд одож, Сааралыг барьсан учрыг Дашдаваагийн эхнэр болоод Сааралын ах Бүрин нарт тодорхойлон сайтар ухуулан мэдүүл хэмээх зарлигийг Жао Хуйд дамжуул. Хэвээр ялыг гагц Сааралаас асуух бөгөөд түүнд хамаагүй, сэжиглэн аюух хэрэггүй болохыг Бүринд ухуул. Сааралын хүүхэд дүү нар хэрэв Цахарын нутагт одоогүй бол бүгдийг Дашдаваагийн харьяатын дотор үлдээж захируул. Хэрэв нэгэнт замд гарсан бол бүгдийг Бээжинд хүргэе.”

Гэгэл дээрх зарлигийн дотор бас,

“並將薩喇爾在伊犁帶回之牲隻物件、俱行查出、奏聞請旨。再薩喇爾自伊犁帶來達什達瓦之子布庫、現在巴里坤。並著兆惠向達什達瓦之妻曉諭、伊等從前投誠時、

¹⁰⁹ Магад хууль (Гаозун хааны), дэвтэр 495, Тэнгэрийн Тэтгэсний 20 оны 8 сарын хөхөгчинүхэр (24) өдрийн зурвас.

¹¹⁰ Зүүнгарын бодлогын бичиг, Жинхэнэ тэмдэглэл 26, Тэнгэрийн Тэтгэсний 21 оны 3 сарын хөхөгчин тахиа (17) өдрийн зурвас.

並未言達什達瓦尚有子嗣。倫鄂齊爾·布林等至京、亦未奏及。其中不無可疑。伊等或聽從薩喇勒一人之言、附和朦混。不可不究問明白、令將實情供出。奏聞後、再行酌量辦理。¹¹

“Мөн Сааралын Ирид хураасан бүх мал байцаан гаргаад сонсгон айлтгаж, зарлигийг гуй. Бас Сааралын Илээс дагуулан авчирсан Дашдаваагийн хүү Бөх, эдүгээ Бархөлд буй. Жао Хуйд тушааж, Дашдаваагийн эхнэрт ухуулж, урьд тэд даган ирсэн цагт Дашдаваагийн хүүгийн тухай хэлсэнгүй. Очир, Бүрин нар бүгд Бээжинд ирсэн үед ч энэ тухай айлтгаагүй. Үүнийг яахин сэжиглэхгүй байж болно. Тэд хэрэв гагц Сааралын үгийг дагаж, будилаантуулжээ. Байцааж тодорхойлж, үнэн байдлыг гаргахгүй бол болохгүй. Айлтган сонгосны хойно, дахин зохихыг үзэж шийтгэе.”

хэмээсэнчлэн, Саарал Илээс Дашдаваагийн хүү Бөх (böke, 布庫) гэгчийг дагуулж ирсэн аж. Өөрөөр хэлбэл, Дашдавааг залгамжлах хүү, түүний харьяатын захирах хууль ёсны эзэн байсаар атал Саарал түүнийг айлтгаж мэдүүлсэнгүй. Анх Саарал Амарсанаагийн “хонхой сэтгэлийг” буруутган айлтгаж, Дашдаваагийн харьяатыг энгийн болгосон, тэгснээр түүний ах нь бүгдийн дарга болсон, мөн дээрх Бөх гэгчийн тухай Дашдаваагийн эхнэр болоод зайсан нар дээр мэдүүлээгүй зэргээс үзэхэд, урьд зайсан, дараа туслагч жанжин байсныгаа ашиглан Саарал Дашдаваагийн харьяатыг өөрийн нөлөөн дор байлгаж байжээ.

1756 оны 4 сард Сааралыг барьмагц, Тэнгэрийн тэтгэсэн хаан Дашдаваагийн харьяат нарыг сэжиглэж, урвах-зугтахас сэргийлж, тэднийг харгалзаж байсан хуувийн сайд Жао Хуйд тушааж, “Сааралын үйлдсэн ялд тэд ямар ч хамаагүй”, “Алтайд нүүж амар тайван амьдрах”-ыг дахин ухуулав.¹² Тэр үеэр Дашдаваагийн эхнэр нас барсан ба түүний харьяатыг Дашдаваагийн дүү Бэгэлийн харьяаттай нийлүүлж, гурван хошуу зохиохоор болж, бүгдийн дарга гурав, дэд бүгдийн дарга зургааг томилов.

“諭軍機大臣曰、達什達瓦之妻、現已病故。著公明瑞馳驛前往、率同侍讀學士富森、土默特台吉喇嘛扎卜等、奠醖茶酒。並加恩賞銀二百兩。經理喪事。其所屬人衆、著編爲三旗、移住阿爾台地方、交與舒明·阿蘭泰等、善爲經理。散秩大臣鄂齊爾·布林·托里、俱著授爲總管。其宰桑鼐瑪克·察罕庫本·們都巴雅爾·博羅呼爾哈·阿爾該·默濟格等、俱著授爲副總管。其應補授叅領·佐領、及編設旗分事宜、一并妥協辦理。具奏請旨。所有達什達瓦之弟伯格里屬人、亦著鄂齊爾等轄。達什達瓦之妻止有一女、著給與郡王青滾雜卜爲妻、並賞銀三百兩。¹³

“Дээрх цэргийн тухайн сайд нарт зарлиг буулгасан нь. Дашдаваагийн эхнэр эдүгээ өвчнөөр үгүй болов. Гүн Мин Руй-д тушаах нь: Өргөөгөөр одож, бичгийн дэслэн уншигч сайд Фүсэн, түмэдийн тайж Ламжав нарыг дагуулан, оршуулгын цай, архи өргө. Бас хишиг хүргээж хоёр зуун лан мөнгө шагнаж, оршуулгын ажлыг гүйцээ. Түүний харьяат ардыг гурван хошуу зохиож, Алтайд нүүлгэн, Шүмин, Арантай нарт тушааж, сайхан шийтгүүл. Сул сайд Очир, Бүрин, Туулыг бүгд бүгдийн дарга болго. Зайсан Фумаг, Цагаанкүбэн, Мэндбаяр, Борхурга,

¹¹ Мөн дээрх.

¹² Зүүнгарын бодлогын бичиг, Жинхэнэ тэмдэглэл 27, Тэнгэрийн Тэтгэсний 21 оны 4 сарын улаан луу (19) өдрийн зурвас.

¹³ Зүүнгарын бодлогын бичиг, Жинхэнэ тэмдэглэл 26, Тэнгэрийн Тэтгэсний 21 оны 4 сарын цагаан хулгана (3) өдрийн зурвас.

Аргай, Мэжиг нарыг бүгд дэд бүгдийн дарга болго. Мөн залан, сумын занги томилох болоод хошуу зохиох хэргийг дараа дараагаар зохиыхыг үзэж шийтгээд, айлтгаж зарлигийг гуй. Дашдаваагийн дүү Бэгэлийн харьяатыг мөн Очир нарт захируул. Дашдаваагийн ганц охиныг жүн ван Чингүнжавт эхнэр болгон өгч, гурван зуун лан мөнгө шагна.”

Мөн доор дурдах Шүмин нарын айлтгалаас үзвэл, Бархөлийн орчимд байх үеэр Сааралын авчирсан Дашдаваагийн хүү Бөх нас барсан аж.¹⁴ Тийм ч учраас дээр дурдсанчлан бүгдийн дарга, дэд бүгдийн дарга нарыг томилсон буй за.

2. Хошуу сум зохиосон ба Алтайгаас Орхонд нүүсэн нь

Бичгийн дэслэн уншигч сайд Фүсэн (fusen, 富森) Дашдаваагийн харьяатыг дагуулан Тэнгэрийн Тэтгэсний 21 он буюу 1756 оны 6 сарын 16-нд Бархолоос гарч, 8 сарын 4-нд Алтайн Бодончид хүрчээ. Чингээд Фүсэн Бодонч, Үенч голд нутаг заахын хамт сум зохиожээ. Чингэхдээ Алтайн хойт Намир, Шаазгайн газар сууж байсан Гадаад Монголын Төрийн Засах Явдлын Яам(ГМТЗЯЯ)-ны жигүүрийн сайд Шүмин, хуувийн сайд Арантай нарын хамт,

“cara aniya durbet hoit hošot dahame jifi gūsa niru banjibure de emu tangkū susai haha ci fusihūn tangkū haha ci wesihun ningge be emu niru, tangkū haha de isinarakūnge be hontoho niru obufi gūsa tome gūsa be kadalara janggin, meiren i janggin emte, sunja niru ci wesihun gūsade jalan i janggin juwete, sunja niru ci fusihūn gūsade jalan i janggin emte, niru tome niru janggin, funde bošokū emte, ajige bošokū duite, juwan boigon de juwan booi da emte goibume sindaki semen wesimbufi yabubuha be dangsede ejehebi.¹⁵”

“Уржнан жил Дөрвөд, Хойд, Хошууд дагаар орж, сум зохиох цагт 150 эрээс дооших, 100 эрээс дээшхийг нэгэн сум, зуун эр хүрэхгүй бол хондого зохиож, хошуу бүрт хошуу захирах занги, мэйрэн занги тус бүр нэг, таваас дээц сумтай хошуунд залан хоёр, таваас доош сумтай хошуунд залан нэг, сум тус бүрт сумын занги ба орлон хөөгч нэг, хөөгч дөрөв, арван гэр тутам аравны дарга нэгийг томилсугай хэмээн айлтгаж явуулсныг дансанд тэмдэглэжээ.”

хэмээн зөвлөлдөж, дөрвөд, хойд, хошууд нарыг сум зохиосон ёсоор сум зохиожээ. Тухайлбал, Дашдаваа болоод Бэгэлийн харьяат 6800 гаруй хүнийг 9 бүтэн сум, 9 хагас сум буюу хондогоор 3 хошуу зохиож, хошуу бүрт сул сайд буюу бүгдийн дарга нэг, мэйрэн занги буюу дэд бүгдийн дарга хоёрыг томилсон тул хошуу захирах занги тавилгүй, залны занги хоёр, сум бүрт сумны занги нэг, орлон хөөгч нэг, хөөгч дөрөв, арван гэр бүрт аравны дарга нэгийг томилжээ. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл дараах мэт.

(Оггийн нэрийг тэмдэглэсэн янзаар манж хэлээр галиглав)

¹⁴ БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр архив, данс 3, Цэргийн тухайн газрын манж дансны хуулга, 1602—023, 042—3125. Хойшид Айлтгалын эвхмэл гэх болно. Дансны дугаар нь “Чин улсын хязгаар нутагт холбогдох манж дансны бүртгэл” (『清代边疆满文档案目录』中国第一历史档案馆·中国人民大学清史研究所编、中国社会科学院中国边疆史地研究中心、广西师範大学出版社, 1999) -д бүртгэгдсэн дугаар болно. ТТ 21 оны 7сарын 17 өдөр хааны үзсэн Шүмин нарын айлтгал.

¹⁵ Айлтгалын эвхмэл 1627-010, 044-1317, Тэнгэрийн Тэтгэсний 21 оны 9 сарын 13 өдөр хааны үзсэн Шүмин нарын айлтгал.

	Отгийн нэр	Эрийн тоо	Сумын тоо	Хошууны түшмэд					Хошууны нэр
				Бүгдийн дарга	Дэд бүгдийн дарга	Залны занги	Сумын занги	Орлон хөөгч	
1	kutucinar	221	1.5	1	2	2	5	5	Зүүн гарын хошуу
2	Galdzat	157	1						
3	cubadak	280	1.5						
4	jisa	83	0.5						
5	kutucinar	221	1.5	1	2	2	5	6	Баруун гарын хошуу
6	erketen	179	1						
7	gubet	177	1						
8	[балархай]	53	0.5						
9	hoise	52	0.5						
10	ontuges	85	0.5	1	2	2	5	5	Дунд хошуу
11	dogolot	90	0.5						
12	širas	174	1						
13	hūrma	179	1						
14	Бэгэлийн харьяат	290	1.5						
	Бүгд	2241	бүтэн 9 +хагас 9	3	3	6	15	16	3

Тэднийг гурван хошуунд хуваасан нь Фүсэнгийн айлтгаснаар “тэд язгуураас баруун зүүн гарт хуваагдаж байсантай” холбоотой аж. Доорх хүснэгтээс үзвэл, Дашдаваагийн харьяат нар 13 отгоос бүрдэж байсан ба тэрхүү отог бүрийн эрийн тооноос хамаарч нэг бүтэн буюу бүтэн хагас сум зохиожээ. Отгийг захирч байсан зайсанг бүгдийн дарга, мэйрэн занги, залны занги, сумны занги тавиад, отгийн хүн амаас хамаарч хондого буюу сум болгосон байна. Өөрөөр хэлбэл, тэдний уламжлалт нийгмийн зохион байгуулалтад чанарын бус хэлбэрийн өөрчлөлт хийсэн, тухайлбал отгийг сум буюу хондого, түүнийг захирагч зайсанг бүгдийн дарга зэрэг тушаалд тавьж хошуу, сум зохиожээ. Чингэхдээ дөрвөд, хойд, хошуудын “хууль” буюу жишгийн дагуу зохиосон тул тэднийг мөн л энэ мэтээр “хошуу, сум зохиосон” буй за.

Зүүнгар хуучин шинэ тус бүр 12 отог, 21 анги, лам нарыг захирах 9 жасаас бүрэлдэж байсан. отог нь ханд шууд, анги нь тайж нарт захирагддаг байсан гэдэг. 21 ангийг цоросын Даваач, Дашдаваа, Галсандорж, дөрвөдийн тайж Цэрэн, хойдын Амарсанаа нарын 21 тайж захирч байсан.¹⁶ Дээрх хүснэгтээс, бид Зүүнгарын нэгэн ангийн бүрэлдэхүүн, жишээлбэл *hoise* буюу хотон нар нэгэн отог болж явсан зэргийг мэдэж болох ба энд нэр гарах *kutucinar*, *Galdzat*, *erketen*, *širas* нь ханы шууд харьяат 24 отгийн нэр билээ. Зүүнгарт отгийг тайж нарын харьяатаас татаж байгуулсан хэмээх тул отог ба тайжийн харьяат ангийн нэр давхардах нь зүй ёсны хэрэг буй за.

¹⁶ Магад хууль (Гаозун хааны), дэвтэр 695. Тэнгэрийн Тэтгэсний 28 оны 9 сарын хар морь (28) өдрийн зурвас.

Тийнхүү сум зохиож, түшмэд томилсны дараа Фүсэн нэг өрхөд 1 үхэр, 4 хонь, хошууны түшмэдэд нэг дахин их мал болоод хүнс шагнан өгөөд, дараа жилээс тариа тариулахаар болов. Тариа тарихын тулд нутаг зааж өгөх хэрэгтэй болж, Алтайн Бодонч, Үенчийн орчим Хотон овоо, Булган голоор нутаглуулах болжээ.¹⁷ Тухайн үед Бодончоос баруун тийших Эх аралд Дөрвөд, баяд нар түр нутаглаж байсан бөгөөд Дашдаваагийн харьяатыг Бодончид нүүн ирэх үеэр Дөрвөд, баяд нар уг нутаг Эрчист нүүсэн учир харуулын доторх газар болох Эх аралд нүүлгэхээр болов. Гэтэл Шүмин нар Эх арал, түүнтэй залгаа Улаангомьн газарт 7000 орчим хүн багтахгүй гэж үзэв.

“damu eke aral i ba kemuni onco leli bicibe noor de nimaha tongga, šurdeme minggan ba hamime ongko muke umesi juken bisire akū. ulan gum emu farsi ba usin tarici ojoro. gojime jaci nuhaliyan, galman ija labdu, niyalma nukteme banjinarakū. ere aniya durbet i urse nukte hafrahūn jalin aha suming be umainaci ojurakū hotogoit i hanci beile cedenjab i nukte be dergi baru anabufi majige jalgiyanjame gaifi geli uriyanghai sei juwari nuktere hanggilcak be ejelefi arkan emu juwari nuktebuhe.”¹⁸

“Гагц Эх аралын газар басхүү агуу уудам авч нуурын загас тоотой, эргэн тойрон мянган газар бараг өвс ус машид хүрэлцэх бус. Улаангом нэгэн хэсэг газар тариа тариваас болох. Гэвч хэт хотгор, батгана хөх түрүү үлэмж, хүн нутаглан, аж төрөхгүй. Энэ жил Дөрвөдийн ард нутаг цухал учир боол Шүмин бид хэрхэвч болохгүй хотгойдын ойр бэйл Цэдэнжавын нутгийн зүүн захыг талбиж өгч, баахан аргацаан өгч, бас урианхай нарын зун нутаглах Хангилцагыг эзэлж, арай хэмээн нэгэн зун нутаглуулав.”

Тэгээд ч Эх арал нь халхын “машид зовсон” учрыг гаргаж, бослого гаргасан жүн ван Чингүнжавын нутаг хотгойдтой, мөн Чингүнжавын харьяат урианхайтай хязгаар нийлэх газар билээ. Тиймээс Шүмин нар Эх арал, Улаангомд Дашдаваагийн харьяатыг суулгахаас болгоомжилж, Орхонд нутаглуулах санал гаргажээ.

“ne dasidawa i fejergi urse komso akū. ere jergi bade nuktebuci baktara de mangga teile akū hotogoit, uriyanghai, kalkai nuktei emgi kūhūfi[kūthūfi], baita dekdebure be akū obume mudarakū. tere anggala ne jing kalkasai burgišame curgindure ucuri, ulet sebe gajifi tebuci taka banjinarakū bime. uthai usin taribure use faha seci uliyasutai de beleningge akū. hūhū hoton ci gajire de, ula hūdai urse be juwebure de inu taka majige mangga gese. eitereme gūnici, enduringge ejen esebe hūdukan i sain nukte bahafi, usin weilebume. sukdan sirabume enteheme banjire doro de dahūkini sere jalin. ede urunakū gosingga gūnin de acabume lak seme sain nukte de icihiyame tebuci, teni goroki be bilure ten i gūnin de acanambi. eke aral i hanci ulan gum ci tulgiyen, ere šurdeme usin nukte juwe de gemu sain ojoro nukte akū. orkon i ba usin huwecki, ongko muke umesi sain. heo seme dasidawa i urse be tebuci ombi.”¹⁹

“Эдүгээ Дашдаваагийн харьяат ард цөөн бус. Энэ зэрэг газар нутаглуулбаас багтахад хэцүүгээр үл барам хотгойд, урианхай, халхын нутагтай хамт хутгалдаад, хэрэг дэгдэхийг үгүй болгож чадахгүй. Тэр ч байтугай эдүгээ халхчууд үймэн цурхиралцах учир өөлд нарыг аваачин суулгаваас түр аж төрөхгүй амуй. Даруй тариа тариулах үр цом хэмээвээс Улиастайд бэлдсэн зүйл үгүй. Хөх хотоос авч ирэхэд улаа худалдааны ардаар мөн хэсэг баахан бэрх мэт. Эргэцүүлэн бодвоос, Богд эзэн эднийг хурдхан сайн нутаг олж, тариа тариулж амьдрал залгуулж, үүрд

¹⁷ Айлтгалын эвхмэл 1627-010, 044-1317. Тэнгэрийн Тэтгэсний 21 оны 9 сарын 13 өдөр хааны үзсэн Шүмин нарын айлтгал.

¹⁸ Айлтгалын эвхмэл 1627-009, 044-1338. Тэнгэрийн Тэтгэсний 21 оны 9 сарын 13 өдөр хааны үзсэн Шүмин нарын айлтгал.

¹⁹ Мөн дээрх.

аж төрөх замыг сэлбэе хэмээх учир. Үүнд эрх үгүй өршөөлт санаанд нийлүүлэн үтэр сайн нутагт шийтгэн суулгаваас, сая хол дахиныг номхотгох туйлын санаанд нийцнэ. Эх аралын ойр Улаангомоос гадагш, энэ орчимд тариа, нүүдэл хоёрт цөм сайн таарах нутаг үгүй. Орхоны газар тариа өн, өвс ус машин сайн. Бардаагаар Дашдаваагийн ардыг суулгаваас болмуй.”

Тэгээд Тэнгэрийн тэтгэсний 21 (1756) оны 11 сар гэхэд Дашдаваагийн харьяат нар 1754 онд Амарсанаагийн дагуулж ирсэн хойд, хошууд нар сууж байсан Орхонд нүүж ирэхэд, Тэнгэрийн тэтгэсэн хаанаас Улиастайн жанжин Цэнгүнжавт (**cenggünjab**, 成衮扎布) халхад нүүсэн Дашдаваагийн өөлдийг чандлан захирах, хэрэв сэжиг бүхий байвал шууд “хядаж”, эхнэр хүүхдийг нь халхуудад боол болгон өгөхийг тушаав.

“上、諭軍機大臣曰、額林哈畢爾噶等處厄魯特等、同謀叛逆、已派兵辦理。著傳諭成衮扎布等、現在達什達瓦 屬人等、住居鄂爾昆地方。如果安靜無事、毋庸辦理。倘稍有可疑、命著成衮扎布發兵前往、尿滅。其子女等、俱賞給喀爾喀等爲奴。成衮扎布務宜詳慎辦理。²⁰”

“Дээрх, Цэргийн тухайн сайд нарт зарлиг буулгасан нь: Эрэн хавирга зэрэг газрын өөлд нар бүгд урван тэрэлснийг хэдийн цэрэг илгээж шийтгэв. Цэнгүнжав нарт тушаах нь: Эдүгээ Дашдаваагийн харьяат ард Орхоны газар сууж буй. Хэрэв хэрэг гаргалгүй амар тайван байгаа бол шийтгэх хэрэггүй. Харин өчүүхэн төдий сэжиг гаргасан даруй Цэнгүнжав цэрэг гарган одож, устга. Тэдний эхнэр хүүхдийг бүгд халхуудад боол болгон шагнан өг. Цэнгүнжав хэргийн учир байдлыг хянан үзэж, шийтгэ.”

Тухайн үед Алтайн баруун талд Амарсанааг барихад Манжийн цэрэгт хүчин тусалж байсан хуучин Зүүнгарын томоохон ноёд Манжийн эсрэг боссон, мөн халхад өртөө, харуулын цэргүүдэд албаа орхин нутагтаа харихыг уриалсан Чингүнжав хараахан баригдаагүй байсан учир Манжийн төр халхад суух ойрадууд энэ далимыг ашиглан, урваж зугтахаас сэргийлж, тийнхүү чандлан харгалзаж байсан буй за.

3. Халуун голд нүүсэн нь

Тэнгэрийн тэтгэсэн хаан Тэнгэрийн Тэтгэсний 22 (1757) оны 4 сарын 16-ны өдөр зарлиг буулгаж, Улиастайн жанжны тушаалыг хамаарч байсан Цэвдэнжав нарт Дашдаваагийн харьяатын доторх лам нарыг Халуун голын сүмд нүүн суулгахыг тушаав.

“daiselaha jiyanggiyūn cebdenjab sede jasi. jakan ceni wesimbuhe bade dasidawa i fejergi urse omihon de amcabulhabi sehe bihe. ere jergi urse emgeri omihon amcabuha kai. gūnici ceni dorgi urunakū lama bi. erebe cebdenjab sede jasifi dasidawa i fejergi ursei dorgi bisire lamasas de ulhibu. ceni lamasas tubade yadame banjime omiholoro de isibure anggala ne halhūn be jailara gurung de beleni amba juktehen weilehe. ubade guribufi caliyan ulebume tebuci oihori sain. cebdenjab i baci burin sede fonjifi lamasai ton be getukeleme baicafi ceni cihangga be tuwame ebsi guribure babe uthai icihiyame emu derei donjibume wesimbukini. cihakūngge be ume ergelere. jai ceni lamasai ama eniye. ahūta deote aika dahame jiki serengge bici inu ceni cihangga.²¹”

²⁰ Зүүнгарын бодлогын бичиг, жинхэнэ тэмдэглэл дэвтэр 34, Тэнгэрийн Тэтгэсний 21 оны 11 сарын улаан луу (23) өдрийн зурвас.

²¹ Айлтгалын эвхмэл 1641-003, 045-2320. Тэнгэрийн Тэтгэсний 22 оны 6 сарын 22 өдрийн ХДТЗЭТЖ-ы тушаалыг хамаарсан Цэвдэнжав нарын айлтгал.

“Хамаарсан жанжин Цэвдэнжав нарт захь. Одоо тэдний айлтгасан газарт Дашдаваагийн доорх ард өлсгөлөнд автав хэмээсэн билээ. Энэ зэрэг ард нэгэн удаа өлсгөлөнд автсан буй. Санаваас, тэдний дотор эрх үгүй лам нар буй. Үүнийг Цэвдэнжав нарт захиад, Дашдаваагийн доорд ардын дотор байх лам нарыг ухуул. Тэдний лам нар тэнд ядуу амьдарч, өлсөхөд хүрэхийн оронд эдүгээ Халуунаас зайлах ордонд их сүм үйлдэж дуусав. Энд нүүж цалин идэж сууваас хялбар сайн. Цэвдэнжавын газраас Бүрин нарт асууж, лам нарын тоог тодорхойлон байцааж, тэдний дурыг үзэж нааш нүүлгэх газрыг даруй шийтгэж, нөгөө талаар сонсгон айлтгатугай. Дур үгүйг нь бүү эрүүд. Бас тэдний лам нарын аав ээж, ах дүү нар хэрэв даган ирсүгэй хэмээх аваас мөн тэдний дураар болго.”

Өөрөөр хэлбэл, Орхонд суух Дашдаваагийн харьяат нар өлсгөлөнд нэрвэгдэж, амьдрахад бэрх хэмээн айлтгасанд Тэнгэрийн тэтгэсэн хаан тэдний лам нарыг Халуун голд шинээр баригдсан сүмд суулгаж, цалин өгөхөөр болжээ.

Халуунаас зайлах ордон бол Бээжингээс зүүн хойш 200 гаруй км-т байх Чэндэ хэмээх Мураны авын залгаа газар байгуулсан Манжийн хаадын зуны ордон билээ. Манжийн хаад одоогийн Хятадын Зүүн хойт нутаг болоод Бээжингийн ойролцоо хэд хэдэн авын газартай байсан авч, хамгийн том алдартай нь Мураны авын газар билээ. Энх-Амгалан хаан Мураны авын газрыг Энх Амгалангийн 22 дугаар (1683) онд анх байгуулсан бөгөөд Манжийн хаадын намрын авд хэдэн мянган найман хошууны цэрэг болоод монгол ван гүнгүүд жасаагаар шадар дагуулын хамт бараа болж байв. Тиймээс Мураны авын үеэр хааны буух газрын ойр зуны ордон буюу Халуунаас зайлах ордонг Энх Амгалангийн 42 дугаар (1703) оноос Энх Амгалангийн 47 дугаар (1708) оны хооронд барьсан бөгөөд тэрхүү ордны эргэн тойронд бас “гадаад найман сүм” хэмээгдэх 11 сүм барьсан билээ.

Дээр Тэнгэрийн тэтгэсэн хааны дурдсан шинэ барьсан “том сүм” бол, Тэнгэрийн Тэтгэсний 20 дугаар (1755) онд Зүүнгарыг эзлэсний дараа Тэнгэрийн тэтгэсэн хаан зуны ордондоо Ойрадын дөрвөн ханг цуглуулан их найр хурим үйлдэх зорилгоор, халхыг даган орсны дараа Энх-Амгалан хаан Долоннуурт Буяныг цуглуулагч сүм (彙宗寺) барьсан явдлыг дууриаж, шинээр бариулсан төвд маягийн сүм Хотол энхжүүлэгч сүм (бас Ховчин амгалан сүм ч гэдэг) (普寧寺)–ийг хэлжээ.

Халхад ядуу зүдүү амьдарч байсан Дашдаваагийн харьяат лам, тэдний ойр төрөл Халуун голд нүүхийг хүлээн авчээ. Юу гэвээс, 111 ламаас гадна тэдний ойр төрөл 817 өрхийн 2723 хүн, өөрөөр хэлбэл Дашдаваагийн харьяатын тэн хагас нь Халуун голд нүүх санал гаргажээ. Тиймээс Улиастайн жанжныг хамаарах Цэвдэнжав лам нарын хамт нүүх хүсэлтэй тэдний ойр төрөл, шавь, боол нарт хязгаар тавьж, эцсийн дүнд 251 өрхийн 676 хүнийг Халуун голд нүүлгэх болов. Мөн лам нарын ойр төрөлд бүгдийн дарга Бүрин багтаж байсан боловч Орхонд үлдэх 3700 гаруй хүнийг захирган, үлдээхээр болжээ.²² Гэтэл Орхонд үлдэх болсон хүмүүс,

“ereī onggoło buya ahasi be adarame bahafi dolo cahar i gūsade dosifi. yaya alban de hūsun bume faššaki semen erehunjehe bihe. enduringge ejen i nurhūme isibuha kesi be alihangge umesi ujen

²² Айлтгалын эвхмэл 1651-017, 046-0374. Тэнгэрийн Тэтгэсний 22 оны 8 сарын 9 өдрийн ХДТЗЭТЖ-ы тушаалыг хамаарсан Цэвдэнжав нарын айлтгал.

dade. geli use faha, anja, halha, kunesun Sangnafi orkon i bade usin taribuha turgunde, ere jergi turgun be gelhun akū tuciburakū. te lamasa be dosi guribure ildun de bairengge membe suwaliyame guribufi dorgi bade tebureo.²³

“Үүний урд өчүүхэн боолуудыг хэрхэн олоод дотор цахарын хошуунд оруулж, аливаа албанд хүчин өгч зүтгэсүгэй хэмээн эрмэлзсээр ирсэн болгоо. Богд эзний удаа дараа хүртээсэн хишгийг хүртсэн нь машид хүнд атал, бас үр цөм, анжис, анжисны хошуу, хүнс шагнаж, Орхоны газар тариа тариулсны тул энэ зэргийн учрыг аюумшиг үгүй гарган хэлсэнгүй. Одоо лам нарыг дотогш нүүлгэх ялдарт гуйх нь, биднийг хамт нүүлгэж, дотор газар суулгах ажааму.”

хэмээн хэдийнээс Цахарт нүүх хүсэлтэй байсан тул тийш нүүлгэхийг гуйжээ. Энэ нь Сааралын сум Цахарт сууж байсан явдал, мөн найман хошуунд хуяг болвол цалин авах учир болов уу. Гэвч Цахарт тэдний хэдэн мянган хүнийг багтаах газар байхгүй тул нүүхийг зөвшөөрсөнгүй. Харин Бэгэлийн эхнэр, түүний харьяат нарын цөөн хүнийг Цахарт нүүхийг зөвшөөрчээ.²⁴

Түүний дараа Тэнгэрийн Тэтгэсний 23 дугаар (1758) оны 3 сард Улиастайн жанжин Цэнгүнжав шийтгэвээс зохих хэрэг хэмээн Дөрвөдийг уг нутагт нь буцаах, Дашдаваагийн харьяатыг хаана нүүлгэх тухай айлтгал өргөв. Түүнд,

“dasidawa i urse ne orkon i jergi bade tehebi. kalkasai nukte de hanci suwaliyaganjame tehe ofi hūlha holoi baita kemuni tucimbi. tuleke aniya ceni tariha usin asuru bargiyahakū ofi geli angalai belen use faha šangnaha bicibe aika geli bargiyahakū oci kemuni sirabure ba baibumbime beikuwen erinde amcabufi tungken hūyur de isinara de mangga ombi. uttu ofi aha be uhei hebešefi ese eicibe sirabure be baibure be dahame inamene ne i icihiyaha erin be amcame jakan šangnaha usin faha ci tulgiyen juwe biyai anggala belen bahabufi hafan cooha tucibufi saikan tuwašatabume tungken hūyur de isibume guribuki.²⁵

“Дашдаваагийн ард эдүгээ Орхон зэрэг газарт суумуй. Халхуудын нутагт ойр хольцолдон суусан тул хулгай худлын хэрэг байнга гарна. Өнгөрсөн жил тэдний тарьсан тариа асар хураасангүй учир бас эрх үгүй бэлэн хүнс шагнасан авч хэрэв бас хураах үгүй болбаас басхүү үргэлжлүүлэх газрыг хэрэгсэнэ. Хүйтэн цагаас урьтаж Түнхэнхуюурт хүргэхэд хэцүү болно. Иймд боол бид хэлэлцээд эднийг ер нь үргэлжлүүлэх тул одоо шийтгэсэн цагаас нэхэж сая шагнасан тариа үрээс гадна хоёр сарын амны бэлэн хүнс олгуулж, түшмэл цэрэг гаргаад сайхан харгалзуулан, Түнхэнхуюурт хүргэн нүүлгэе.”

хэмээн Дашдаваагийн ардыг Орхоноос Хармөрөний Түнхэн хуюурт²⁶ нүүлгэх санал гаргажээ. Үүнийг цэргийн тухайн сайд нар Дашдаваагийн ардыг одоо даруй бус, намар ургацаа хураан авсны хойно нүүлгэхээр хэлэлцээд, Хармөрөний Чолду (coldu, 綽爾多) –д хаана суулгаваас

²³ Мөн дээрх.

²⁴ Магад хууль (Гаозун хааны), дэвтэр 538. Тэнгэрийн Тэтгэсний 22 оны 5 сарын цагагчин туулай(1) өдрийн зурвас.

²⁵ Айлтгалын эвхмэл 1687-006, 048-0756. Тэнгэрийн Тэтгэсний 23 оны 3 сарын 24 өдрийн ХДТЗЭТЖ Цэнгүнжав нарын айлтгал.

²⁶ Түнхэнхуюур гэдэг нь Сунгар мөрөнд цутгах Хулан голын салбар Түнхэн(tungken, 通肯) гол, Нон мөрөнд цутгах Хуюур буюу одоогийн нэр Уюур(烏裕爾) голын сав газар юм

зохих газрыг тогтоохыг тушаав.²⁷ Түүний дагуу Хармөрөний жанжин Чолду хаана суулгах тухай дараах мэт айлтгав.

“aha be baicaci, tuleke aniya coohai kūwaran ci benjibuhe juwe meyen i ulet orin nadan uksura be hūyur birai mangnai sere bade nuktere babe jorifi tebuhebi. tungken, hūyur bira siden giyalabuhange juwe tanggū susai ba funcembi. tungken birai ungginai, jak, carabtan sere ilan bade usin tarire. ulha adulara ba gemu bi. te coohai kūwaran ci benjibure dasidawa i fejergi urse be neneme tebuhe ulet sei emu bade tebuci ojorakū be dahame esebe benjime isinjaha manggi tungken birai ungginai i jergi bade nukte joriki.”²⁸

“Боол бид байцааваас, өнгөрсөн жил цэргийн хүрэнээс хүргэж ирүүлсэн хоёр ангийн өөлд хорин долоон угсааг Хуюур голын Магнай хэмээх газарт нутаглах газрыг зааж суулгасан бөлгөө. Түнхэн, Хуюур голын хооронд ташаалсан хоёр зуун тавин газар буй. Түнхэн голын Унгинай, Заг, Чаравтан хэмээх гурван газарт тариа тарих, мал адгуулах газар цөм буй. Эдүгээ цэргийн хүрэнээс хүргэж ирүүлэх Дашдаваагийн доорд ардыг урд суусан өөлд нартай нэгэн газар суулгаваас болох үгүйг дагаж, эднийг хүрч ирсэн хойно Түнхэн голын Унгинай зэрэг газарт нутаг заая.”

Эндээс үзвэл, Тэнгэрийн Тэтгэсний 22 дугаар (1757) онд цэргийн хүрээ буюу Улиастайгаас хүргүүлсэн өөлд, тухайлбал дөрвөд, хойдыг Хуюур голын Магнай хэмээх газар нутаг зааж суулгасан аж. Тэгээд энэ удаа Дашдаваагийн харьяатыг тэднээс хол байлгахын тулд Хуюур голоос 250 газар хол Түнхэн голын Унгинай хэмээх газар суулгахаар болов. Гэтэл тийнхүү Хармөрөнд нүүлгэх шийдвэр гаргасан авч, тэд тийш нүүхийг үл хүсэх байдлыг харгалзан үзэж, нүүхийг түр хойшлуулав.

“又諭、昨成衮扎布等請遷移達什達瓦游牧於通肯呼裕爾。經軍機大臣議奏、俟秋收後辦理。朕即諭成衮扎布等、將遷移游牧之事、不必先使聞知。恐伊等因此懈於耕作。今思達什達瓦游牧移往通肯呼裕爾、恐非伊等本意。若到彼無計謀生、仍須接濟、且或致脫逃、又滋事端。莫若移往察哈爾、或在巴里坤附近阿濟必濟等處游牧。俟巴里坤駐兵屯田等事議定、即令長住亦可。此事仍待朕熟籌交議。著傳諭成衮扎布、此時惟勸課伊等耕種。其應移駐何地、俟議定後、臨時再行曉諭。”²⁹

“Бас зарлиг буулгах нь. Урд Цэнгүнжав нар Дашдаваагийн харьяатын нутгийг Түнхэнхуюурт нүүлгэхийг гуйсныг цэргийн тухайн сайд нар хэлэлцээд, намар ургац хураасны дараа шийтгэхээр болов. Хаан би даруй Цэнгүнжав нарт нутаг нүүлгэх явдлыг түрүүлэн тэдэнд мэдэглэх хэрэггүй, тариа тарихаас залхуурах буй за хэмээн тушаасан. Одоо санаваас, Дашдаваагийн харьяатын нутгийг Түнхэнхуюурт нүүлгэх нь тэдний уг санаа бус хэмээн болгоомжилно. Хэрэв тэд бодлого үгүй аваас хэвээр үргэлжлүүлэн тусалж, эсвээс урван зугтахад хүрнэ. Чингэвэл бас яришиг төвөг болно. Хэрэв Цахар эс бөгөөс Бархөлийн ойр Аж-Биж хэмээх газар нүүлгэсэн ч болох мэт. Хожим Бархөлд сууж тариа тарих цэргийн хэргийг шийтгэж, удаанаар суухыг тушааж бас болмуй. Энэ хэргийг хаан би сайтар тунгааж, харилцан шийтгэе. Цэнгүнжавт одоо тэднээр хичээнгүйлэн тариа тариулах явдлыг уламжлан тушаа. Хаана нүүлгэн суулгах хэргийг хожим хэлэлцэж шийдсэний дараа, тухайг үзэж дахин тодорхойлон айлтга.”

²⁷ Айлтгалын эвхмэл 1693-097, 048-2448. Тэнгэрийн Тэтгэсний 23 оны 5 сарын 19 өдөр хааны үзсэн айлтгал. (бичиг гэмтэлтэй тул хэний айлтгал болох нь тодорхойгүй)

²⁸ Мон дээрх.

²⁹ Магад хууль (Гаозун хааны), дэвтэр 560. Тэнгэрийн Тэтгэсний 23 оны 4 сарын шар морь (3) өдрийн зурвас.

Тэнгэрийн тэтгэсэн хаан Зүүнгарыг дайлахын өмнө 1754 оны 12 сард, бас Чингүнжавын бослогын үед халхад сууж байсан ойрадыг уг нутагт нь буцааж, халхын нутгийг тэлэхээ халхуудад амалж байсан билээ.³⁰ Тиймээс нэгэнт Амарсанаа нас барж, Зүүнгарыг түвшитгэн тогтоосон Тэнгэрийн Тэтгэсний 23 дугаар (1758) онд Дашдаваагийн харьяатыг урьдын адил халхад суулгаад байж болохгүй байлаа. Гэвч Дашдаваагийн харьяат нар Хармөрөний Түнхэнхуюурт бус Цахарт нүүхийг хүсэж байсан тул Хармөрөнд хүчээр нүүлгэхээс татгалзаж, эцсийн дүнд тэдний нэг хэсэг сууж буй Халуун голд нүүлгэх болж, ГМТЗЯЯ-ны түшмэл Самбууд дараах мэт тушаав.

“論軍機大臣等、三寶等、前經呈報達什達瓦屬人窮蹙情形、深可憫惻。已諭將存貯籽種三百石、全行散給。又布林等告稱、伊等情願向遷移、承受恩澤等語。伊等既願內移、則來年交春後、三寶即率領伊等、量力行走、至熱河居住。但計遷移之前、為日尚多、僅止籽種、亦不敷食用。是以從伊游牧、選兵一千名、前往西路。不但入選官兵、優加賞給。即其餘人等、亦酌給三分之一。庶伊等普霑恩賚、不致拮据、似此格外施恩、特因伊等自遷移游牧以來、感戴朕恩、安靜守分。將來支給錢糧、更於生計有益。可傳諭三寶、將此曉示布林等、俾眾皆知悉。”³¹

“Цэргийн тухайн сайд нарт зарлиг буулгах нь: Самбуу нар урд Дашдаваагийн харьяат нар ядуурч зүдэрэн байдлыг мэдүүлсэн нь туйлаас хөөрхийлөлтэй. Хэдийн зарлиг суулгаж, гурван зуун таар амууг бүгдэд тарааж өгөв. Бас Бүрин нар тэдний хүслээр нүүлгэж, хишиг хүртээхийг өргөн мэдүүлжээ. Тэдний дураар дотор газар нүүлгэхийн тулд даруй хойтон хавар Самбуу нар тэднийг дагуулан чадлын хэрээр явж, Халуун голд хүргэж суулгагтун. Харин нүүх хүртэл олон хоног буй, байгаа амуу цөөн, хүнсэнд хүрэлцэхгүй. Мөн тэдний нутгаас мянган цэрэг татаж, баруун замд илгээхийг дагаж, гагц цэрэг бус бүх хүнд тусгай шан хүртээ. Өөрөөр хэлбэл, үлдэх бүх хүнд гурваны нэг хувийг шагнаан өг. Ядарсан ард тэднийг өргөн тэтгэвээс үгүйрч хоосроход хүрэхгүй, энэ мэт онцгойлон харж үзвээс нутаг нүүсний дараа миний [хааны] хишигт сүсэглэн, элдэв хэрэг гаргалгүй амар суух буй за. Шагнаан өгөх мөнгө бас тэдний аж төрөхөд тус болмуй. Үүнийг Бүрин нарт тодорхойлон мэдүүлж, тэдний ардыг сайтар ухуулах явдлыг Самбуу нарт уламжил.”

Тийнхүү Тэнгэрийн Тэтгэсний 24 дүгээр (1759) оны хавар Халуун голд хүрсэн Дашдаваагийн харьяат нар Хотол энхжүүлэгч сүмийн ойр бөөнөөр суух болжээ.³² Сүүлд одсон бүлэг доторх 18 лам урд ирсэн лам нарын нэгэн адил Хотол энхжүүлэгч сүмд сууж, цалин хүртэх болов.

“jai ceni ere mudan jihe ursei dorgi bisire lamasa be fudangga, haiboo se uthai cembe gubci nikton juktehen de tebufi ongolo icihiyame tebuhe lamasai songkoi caliyān ulabukini. ereci Julesi ceni ulet sei dorgi arkan cihanggai juse deote be lama obuki serengge bici, uthai ceni cihai lama obufi inu gubci nikton juktehen de dosimbufi tebume caliyān jetere lamasai oron tucike be tuwame tebufi caliyān ulebukini.”³³

³⁰ О.Оюунжаргал “Тэнгэрийн тэтгэсэн хааны дунд үе дэх Дөрвөдийн нутгийн асуудал” 「乾隆中葉におけるトウルベドの牧地問題について」 Японы Монгол судлалын холбооны мэдээ, №36, 2006, тал 3-15. / япон хэлээр/ Магад хууль (Гаозун хааны), дэвтэр 575, Тэнгэрийн Тэтгэсний 23 оны 11 сарын цагаан хулгана (17) өдрийн зурвас.

³¹ “Зарлигаар тогтоосон Халуун голын тэмдэглэл”, дэвтэр 79, Сүм хийд, Хотол энхжүүлэгч сүмийн зүйл (『欽定熱河志』校點本 / (清)和坤, 梁國治撰; 承德民族師範高等專科學校, 天津古籍出版社, 2003)

³² Айлтгалын эвхмэл 1762-009, 053-0325. Тэнгэрийн Тэтгэсний 24 оны 6 сарын 4 өдрийн Халуун голын мэйрэн зангийн айлтгал.

“Бас тэдний энэ удаа ирсэн ардын дотор байх лам нарыг Фуданга. Хайбоо нарт даруй тэднийг Хотол энхжүүлэгч сүмд суулгаж, урд шийтгэн суулгасан лам нарын ёсоор цалин идүүлтүгэй. Үүнээс хойш тэдний өөлд нарын дотор дураар хөвгүүн, дүү нарыг лам болгоё хэмээх нь байваас даруй тэдний дураар лам болгоод Хотол энхжүүлэгч сүмд оруулж суулгаад, цалин идэх ламын ор гарсныг үзэж суулгаад цалин идүүлтүгэй”

Манжийн үед олон газрын сүмд суух лам нарын ор буюу орон тоо, тэдний цалингийн хэмжээг ГМТЗЯЯ-ны хууль зүйлийн бичигт тодорхой заасан байдаг. Тухайлбал, Халуун голын Хотол энхжүүлэгч сүмийн лам нарын тухайд,

“nigen jüil. qotala engkejigülügči šum-e. qoyar lang čaling idekü demči-yin orun tabun. egün-ü doturača qoladakin-i amurjijuluyči süm-e-dür qubiyar sayulyaysan orun nige. qoyar lang čaling idekü gesküi-yin orun qoyar. egün-ü doturača qoladakin-i amurjijuluyči süm-e-dür qubiyar sayulyaysan orun nige. qoyar lang čaling idekü blam-a-yin orun nigen jayun arban. egün-ü doturača qoladakin-i amurjijuluyči süm-e-dür qubiyar sayulyaysan arban yurban.”³⁴

гэж буй. Энд Хотол энхжүүлэгч сүмийн ламын тоонд Хол дахиныг амаржуулагч сүмийн ламын тоог багтаасан нь анх Хотол энхжүүлэгч сүмд сууж байсан өөлдийн лам нар хожим тэдэнд зориулсан барьсан Хол дахиныг амаржуулагч сүмд шилжин суусантай холбоотой буй за.

Тийнхүү Халуун голд суух болсон Дашдаваагийн харьяат нар уламжлалт мал аж ахуйгаа эрхэлж байсан ба хэд хэдэн удаа Манжийн төрөөс тэдэнд мал хуй шагнан өгсөн байдаг. Харин Тэнгэрийн Тэтгэсний 29 дүгээр (1764) онд бараг хүнгүй шахам болсон хуучин Зүүнгарын нутагт цэрэг, ардыг нүүлгэн суулгах үеэр Дашдаваагийн харьяат болоод Бээжинд сууж байсан өөлд нараас хүслийг харгалзан тийш нүүлгэв.³⁵ Уг нутагтаа буцсан өөлд нарыг гурван хошуунд хувааж, Тарвагатайн хуувийн сайдад захирагдах болжээ. Харин Халуун голд үлдсэн өөлд нар Манжийн хааныг Халуун голд өөд болоор ирэх үед авд бараа болж, найр хуримын хоол хүнсийг бэлтгэж байжээ.³⁶

Дүгнэлт

Тэнгэрийн Тэтгэсний 20 дугаар (1755) онд Манж Чин улсын Зүүнгарыг дайлах хойт замын туслах жанжин болж, Илд буцсан Амарсанаа захирах эзэнгүй Дашдаваагийн харьяатыг өөрийн захиргаанд байлгахыг санаархаж байжээ. Түүнийг Дашдаваагийн зайсан байсан баруун замын туслагч жанжин Саарал дээш айлтгаснаар Дашдаваагийн харьяат нар энгийн болж, зайсан нараар нь захируулах болов. Түүний дараа Амарсанаагийн бослогын цэрэгт ялагдаж, зугтсан Саарал ялд унахад тэрбээр Дашдаваагийн бас нэгэн хүүгийн тухай мэдсээр

³⁴ ГМТЗЯЯ-ны хууль зүйлийн бичиг, дэвтэр 56, Лам нарын хэргийн хууль, тэргүүн. Нэмж зохиосон нь, Нийслэл хот жич олон газрын тушаалын ламын тогтоосон тоо. Дашрамд дурдахад, 1949 оны үед Халуун голын өөлд 100 орчим хүн байсан ба түүнээс хойш 250 болтлоо өссөн аж. Дээр дурдсан Юань Сэн По “Дашдаваагийн ард зүүнш Халуун голд нүүсэн тухай”, тал 183.

³⁵ Зүүнгарын бодлогын бичиг, дараах дэвтэр 23, Тэнгэрийн Тэтгэсний 29 оны цагаан сарын хар бич (20) өдрийн зурвас. Магад хууль (Гаозун хааны), дэвтэр 705, Тэнгэрийн Тэтгэсний 29 оны 2 сарын шарагчин тахиа (27) өдрийн зурвас.

³⁶ ГМТЗЯЯ-ны хууль зүйлийн бичиг, дэвтэр 21, Аялан явахуйд бараа болох хэргийн дундад. Нэмж зохиосон нь, Ре хо дур өөд болоор одох олон хууль ёслол. Мураны дотор элдэв зүйлийн алба хааж явах хүний тоо.

байж мэдүүлээгүй явдал илэрснээс үзэхэд гагц Амарсанаа бус Саарал мөн 7000 орчим хүн бүхий Дашдаваагийн харьяатыг захирах буюу өөрийн нөлөөн дор байлгахыг санаархаж байжээ. Тиймээс Манжийн төр тэднийг Илээс холдуулж, Алтайд суулгахаар болсон авч яг тэр үед Халхад Чингүнжавын бослого гарсан тул халхын нутгийн гүн Орхонд нүүлгэн, чандлан харгалзах болжээ. Тэгээд Тэнгэрийн Тэтгэсний 22 дугаар (1757) онд шинээр баригдсан Хотол энхжүүлэгч сүмд суулгахын тулд Дашдаваагийн харьяат лам, тэдний гэр бүлийг Халуун голд нүүлгэсэн ба үлдэгсэдийг халхын нутагт удаан суулгах аргагүй тул хоёр жилийн дараа мөн Халуун голд нүүлгэжээ.